STUDIA ARCHAEOLOGICA

Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences

DOI: https://doi.org/10.5564/sa.v42i1.2820

Tomus XLII 2023 Fasciculus 7

Батсуурийн Анхбаяр[1,✉], Боржигдай Мөрөн[2], Басандоржийн Буян-Орших[2]

[1]Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Археологийн хүрээлэн. Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө, Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр
[2]Өвөр Монголын Их Сургуулийн Монгол судлалын сургууль, Их сургуулийн гудамж, Хөх хот, ӨМӨЗО, БНХАУ, 010020

Хар хороотын руни бичээс, тамга

Товчлол. Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Баянбүрд багийн нутаг Хар хороот хэмээх газраас руни бичиг, тамга бүхий шинэ дурсгалыг 2022 онд илрүүллээ. Уг бичээсийн агуулгыг урьдчилсан байдлаар уншихад олон алт дэлдэж зоос бүтээсэн тухай гарч байна. Тиймээс уг дурсгалын ойр орчимд буй руни бичгийн сурвалж хийгээд Күльтегиний хөшөөний бичигт гарч буй худалдаа арилжааны тухай тэмдэглэлд дулдуйдан хожуу Түрэгийн хаант улсын сүүл Билгэ хааны үед, эс бөгөөс Уйгурын хаант улсын өрнө зүгт чиглэсэн их замын дагуух эдийн засаг, арилжаа худалдааны харилцааг илэрхийлсэн шинэхэн баримт хэмээн үзэж байна.

Түлхүүр үг: *Хар хороотын бичээс, Хожуу Түрэг, Уйгур, худалдаа арилжаа*

Ankhbayar Batsuuri[1,✉], Bao Wenshen[2], Buyan-Orshikh Basandorj[2]

[1]Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences Building-1. Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia
[2]School of Mongolian Studies, Inner Mongolia University, No:235 Daxue West road, Hohhot, Inner Mongolia, China, 010020

The runic inscriptions and stamps found at the site of Khar khoroot

Summary. We have discovered a new cultural monument with a runic inscription and stamp at the site of Khar Khoroot in the area of Bayanburd Bag, Buutsagaan soum, Bayankhongor aimag. A preliminary study of the contents of the inscription reveals that it was written about creation of a large number of golden coins. Accordingly, basing on the runic source in the vicinity of the monument and the record of trade in the inscriptions of Kultegin monument, we have reached a conclusion that it is a new fact represented economic trade relations along the westward roads of the Uyghur Khaganate during the reign of Bilge Khan, the late Turkic Khaganate.

Keywords: *Inscriptions of Khar khoroot, Late Turkic and Uyghur, Trade*

© Б.Анхбаяр, Боржигдай Мөрөн, Б.Буян-Орших 2023
Email: ankhbayar.b@mas.ac.mn, *https://orcid.org/*0000-0002-9294-8039

Удиртгал

2022 оны 01 дүгээр сард бид Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Баянбүрд багийн Засаг дарга П.Сайнбилэгтэй холбоо тогтоосон юм. Тэрээр төрсөн нутгийнхаа түүх, соёлыг сурвалжлан мэдэхийг хичээдэг, гэрэл зураг сонирхдог тун идэвхтэй хүн бөгөөд урьд Бууцагаан сумын Соёлын төвд ажиллаж байхдаа өөрийн биеэр цуглуулсан болон үзэж харсан дурсгалт газруудынхаа тухай гэрэл зургаар баримтжуулан бидэнд илгээж, тэдгээрийг чухам хэдий үед холбогдох, ямар дурсгал болохыг нь мэдэх хүсэлтэй байгаагаа уламжилсны зэрэгцээ зарим дурсгалууд санаатай санамсаргүй байдлаар сүйдэж байгааг хэлж, ихэд харамсаж явдгаа илэрхийлсэн юм. Түүний явуулсан гэрэл зургууд дотор руни бичгийн дурсгал байсан нь бидний судалгааны сэдэл болсон билээ. Уг дурсгалын тухай лавшруулан сураглахад айлын хаваржаанд шахуу байдаг, мал хуй гэмтээх магадтай тул өвөлжөөний эзэн чадлын хэрээр хамгаалдаг болохыг мэдэж авсан.

Иймээс дээрх дурсгалыг сүйдэхээс өмнө үзэж нягтлах, эрдэм шинжилгээний тодорхойлолт хийхээр ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Анхбаяр, гэрээт ажилтан Б.Буян-Орших нар 2022 оны 09 дүгээр сарын 12-ноос 17-ны өдрүүдэд томилогдон очиж ажиллав [Анхбаяр, Буян-Орших 2022: 7].

Түүнчлэн руни бичгийг тайлж уншихад туслахыг хүсэж Өвөр Монголын их сургуулийн багш түрэг судлаач Боржигдай Мөрөнд хандсанаар бидний хамтын судалгаа болсон юм. Хар хороотын бичээс, тамганы тухайд урьд хэвлэгдэж, нийтлэгдээгүй учир шинээр илэрсэн дурсгал хэмээн үзлээ.

Судалгааны хэрэглэгдэхүүн

Бууцагаан сумын Баянбүрд багийн төвөөс зүүн хойш 17 км зайд, Аав Богд уулаас зүүн тийш 2 км орчим зайд зүүн урагш чиглэсэн амны эхэнд шахуу Улаан хошууны Хар хороот хэмээх газарт малчин Сааралын Ганбатын хаваржааны арын хаданд дурдаж буй руни бичгийн дурсгал байна. Хар хороотын ар талд тэр чигтээ хар бараан өнгийн чулуулаг бүхий сунаж тогтсон хадархаг тээг аж. Уг газар нь Хангайн нурууны баруун өмнөд биеийн өвөрт, Байдраг голын савд хамаарна. Дурсгал олдсон газрын баруун талд буй Аав Богд уул нь Хангайн нурууны өндөр уулсын системд хамаарах далайн түвшнээс дээш 3050 м өндөрт өргөгдсөн сүрлэг уул бөгөөд энэ орчмын хэдэн сумын малчдын шүтээн, тахилгат газар болно. Дурсгалт газарын байршил: N 46° 32′ 35.40″; E 98° 59′ 46.24″ хэмийн солбицолд, далайн түвшнээс дээш 2211 м өндөрт оршиж байна (Зураг 1).

Хаваржааны арын хадат эргийн зүүн доор буюу хаваржааны байраас зүүн хойш 35 м орчим зайд том асга хадтай хэсгийн хөлд буй босоо зууван хэлбэртэй 110 x 66 x 48 см хэмжээтэй нэгэн хүрэн хадны баруун өмнө зүг хандсан нүүрэнд 1 мөр 14 тэмдэгт болон 3 тамга бий. Бичээсийн урт 60 см орчим ажээ. Үсгийн хэмжээ дунджаар 5 см. Энд хаваржиж, намарждаг малчин С.Ганбат нь бичигт хадыг олон жилийн өмнөөс олж мэдээд бог мал гатчин эвдэхээс сэргийлж дээр нь төмөр сав тавьж хамгаалдаг байсан гэнэ. Бичиг, тамга хэдийгээр тодхон харагдах боловч хадны гадаргуу барсгар учир хэв хуулга авах боломжгүй, гүн бус ажээ. Бичгийн дээд захад ташуу зураас, түүний ойр хэдэн тамга мэдэгдэж байв (Зураг 2).

Судалгааны арга зүй

Руни бичгийн дурсгал гарал үүслийн асуудалд ч, руни бичгийн дурсгал үлдээгчдийн овог аймаг, он цагийг тодруулан судлахад ч бичээст шууд ба дам холбогдох тамгаас салангид авч үзэх боломжгүй юм [Баттулга 2022; 19]. Бид дээрх тодорхойлолтод тулгуурлан дараах арга зүйг ашиглав. 1-рт, археологийн хайгуул судалгааны үндсэн арга зүйг ашиглан дурсгалт газрын байр зүй, хадгалалт, дурсгалын хэлбэр хэмжээ зэрэг шинж чанарыг тодорхойлж баримтжуулав. 2-рт, эх бичгийн дурсгалыг уншиж, өмнөх бичгийн дурсгалуудтай харьцуулан он цаг тогтоох арга ашиглав. 3-рт, сүүлийн жилүүдэд судлаачдын анхаарах болсон тамга судлалын харьцуулах аргыг ашиглах оролдого хийлээ.

Судалгааны хэлэлцүүлэг

Баянхонгор аймгийн Бууцагаан сум болон ойр орчмын сумдын нутгаас руни бичгийн хэд хэдэн дурсгал олдож байжээ. Хар хороотын бичээсээс баруун урагш 40 км зайд орших Замын бууцны бичээсийг HT 790-791 оны орчимд Уйгурын их цэргийн бүрэлдхүүнд багтаж Хангайн нурууны өврөөр өнгөрч, Алтайн нурууг давж явсан Эдиз аймгийн нэгэн ахлагч сийлж үлдээжээ [Munkh-tulga 2020: 366]. Харин зүүн урагш 50 км орчим зайд Бөмбөгөр сумын нутагт буй Бөмбөгөрийн бичээс нь HT 744-745 оны үед Карлук, Басмыл аймгуудтай холбогдох аж. Бичээст эртний түрэгийн заншил ёсоор тэнгэрт хальсан Илбислиг гүнжийг чандарлан, тахил тайлга үйлдсэн тухай [Баттулга 2005: 117-124, Баттулга 2020: 100-103] өгүүлдэг байна. Бидний олсон дурсгалаас хамгийн ойр буюу баруун урагш 20 км зайд буй Гурван Мандал уулын бичээст хуяг дуулгатай нэгэн баатар эрийг алтан эмээлтэй энгэсэгт охид Ачака, Карагаз нартай уулзалдсан [Болд 1990: 25-27, Баттулга 2005: 125-135] тухай гардаг. Харин баруун тийш 25 км зайд буй Бөмбөгөр сумын

Далтын бичээст ан ав, адуу малд явахдаа бичиж үлдээсэн бололтой Күнчир [Баттулга 2022: 114] хэмээгчийн нэрийг сийлжээ. Дурсгалаас баруун урагш 50 км орчимд Хиргисийн овооны бичээст Түрэг түмнийг далан түм болгосон, Огуз түмнийг нэгэн ханд захируулж, дөрвөн зүгийг төвшитгөх үйл хэрэгт бүх насаа зориулсан зэрэг [Баттулга 2022: 126-138] агуулга илэрсэн аж. Тэгвэл Хар хороотын бичээсийг дараах мэт уншин толилуулж байна.

Эх бичгийн уншлага:

Дүрсийн галиг: ytmsltwNBSITtdm (Латин галигт том үсгээр чанга гийгүүлэгч, харин бага үсгээр сул гийгүүлэгчийг тэмдэглэв).

Уншлагын галиг: yitmis altun basit tidim (доор нь зураастай галиг бол эгшгийн нэмэлт)

Монгол орчуулга: Далан алтан зоос дэлдэв би (олон алтаар зоос хийв би) (Зураг 3).

Тайлал: Тус бичлэгийн тигээс харахад түрэгийн үеийн бичээстэй адилавтар харагдана. Бичээст гарч буй "Далан" хэмээх нь "Олон" гэсэн утгыг илэрхийлдэг. Даруй "Олон алтаар дүүргэв би" гэсэн өгүүлбэр байна. Энэ бичээс нь юуны урьд Түрэгийн хаант төрийн арилжаа худалдаагаар улс орноо хөгжүүлэх гэсэн бодлоготой холбоотой мэт сэтгэгдэл төрүүлнэ. Хятад сурвалж ба археологийн дурсгалаас харвал Хожуу Түрэгийн хаант улс согд хүмүүст түшиглэн арилжаа худалдааг өрнүүлэн, улс орноо хүчирхэгжүүлэх гэсэн бодлогыг хэрэгжүүлж байлаа. Онцгойлон Билгэ хааны үед арилжаа худалдааг ихэд дэмжсэн байна. Энэ тухай Күльтегиний гэрэлт хөшөөний өмнө талын 4-р мөрөнд "Улс цогцлоох газар болбол Этүгэний уулс (Хангайн нуруу) байжээ. Энэ газар сууж Табгач иргэн (Тан улс) лугаа аялдан харилцав. Алт, мөнгө, торго, хэмэрлэг зэргийг тоолшгүй ирүүлнэ"[Talat Tekin 2010:20] гэжээ. Бас өмнө талын 8-р мөрөнд "Этүгэн нутагт сууж худалдаа наймаа илгээвэл ямар ч зовлон алга. Этүгэн газар орлон суувал мөнхийн улсыг цогцлоон сууна чи..." [Talat Tekin 2010:22] хэмээн тэмдэглэжээ. Энэ агуулгаас үзвэл Билгэ хаан арилжаа худалдаагаар дамжуулан улсаа хөгжүүлэх бодлогыг эрчимтэй оролдож байжээ. Тиймээс Хар хороотын бичээс нь Билгэ хааны үед арилжаа худалдааг хөгжүүлэх төрийн бодлогын түүхэн орчинд бичигдсэн байж болох саналыг дэвшүүлье.

Тамга: Хар хороотын бичээстэй хамт 3 тамга бий. Тэдгээр нь бичвэрийн дээд хэсэгт байрлана. Бичиг бүхий талын эхний үсгээс дээш 7 см орчим зайнаас баруун дээд үзүүрээс зүүн дээд үзүүр хүртэл 27 см үргэлжилсэн ташуу зураас татжээ. Уг зураасны зүүн дээд талд 1 см орчим зайд 2.6 см голчтой төвдөө цэгтэй онги тамга, зураасан хашлагын төвөөс доош 2.9 см зайд доошоо харсан үзүүртээ 3 салаа хэлбэртэй 6 см урт иштэй гаднаа 10 см, дотор талдаа 2.5 см голчтой төвдөө цэг бүхий давхар онги тамга тус тус бий. Тэдгээрийн зүүн доор 1 см зайд болон бичвэрээс баруун тийш 5 см зайд, зүүн зүг харсан 3 х 4 см хэмжээтэй янгир тамга бий. Дээрх тамгуудын зарим нь судалгааны ном бүтээлд нэгэнт тэмдэглэгдсэн байна. Тодруулбал, янгир тамга нь хожуу түрэгийн үед холбогддог "Эширийн баруун гар тийш харсан янгир" [Мөнхтулга нар 2022: 41] тамга, онги болон иштэй онги тамгууд огузын нэгэн салбар Пугу нартай холбогдох боломжтой [Батболд 2017: 168-175] ажээ. Эширийн (Ашина) янгир тамга нийт 50 орчим олдсоноос дийлэнх нь Монгол нутгаас илэрсэн байхаас гадна хоёр тамгатай хамт гурвалсан байдлаар дүрслэгдэх явдал тохиолддог аж [Барс нар 2022: 79-85]. Харин давхар онгитой залгасан сэрээ мэт иштэй үүсмэл тамгын хувьд бидний олж үзсэн хэрэглэгдэхүүнд тохиолдсонгүй. Тэгвэл төвдөө цэгтэй онги тамга Говь-Алтай аймгийн Бигэр сумын Хөшөөт толгойн бичээсийн дэргэд хамт олдож байжээ. Судлаачид уг тамгыг сурвалжийн мэдээнд тулгуурлан Огузын Тонра аймагтай холбож үзсэн байна [Баттулга 2022: 125]. Эндээс үзвэл уг тамга Тонра, Пугу аймгуудын оролцоотой бүтсэн болохыг ерөнхийд нь төсөөлж болно. Ер нь Тонра, Пугу аймгуудын холбоо хамаарлын талаар судлаачид өмнө олон ажиглажээ. Энэ хэрэг явдал Хуучин Тан улсын бичигт өгүүлснээр 661 онд Тонра, Пугу аймгууд холбоолон Тан улсын эсрэг зэвсэглэн боссон [旧唐书 1971: 传195, 5197] явдлаас эхлэлтэй. Уг тэмдэглэлүүд дотор угсаа төрлийн болон газар усны ойрын тусгал [Мөнхтулга нар 2022: 45] хэмээн үзсэн тохиолдол ч буй. Харин хэмжээний хувьд бусдаас том, иштэй цэг бүхий давхар онги тамганы эзний талаар одоогоор шууд хэлэх боломж хомс байна. Ямар боловч уг тамга бичээст гарч буй агуулгад голлох байр суурийг илэрхийлэгч бололтой. Энэ утгаараа гэрэлт хөшөө хад чулууны бичээст үйлдүүлэгч, үйлдэгч нар овог аймгийнхаа тамгыг үлдээх нь тэр үеийн бараг тогтсон ёс, уламжлал байсан [Баттулга 2022: 126] хэмээх ойлголт үнэнд ойр болов уу.

Гэвч дундаа цэг бүхий онгигүй боловч үзүүртээ салаа иштэй тамга Хар хороотын дурсгалаас холгүй орших Гурван Мандал уулын дурсгалд бий [Баяр 2013: 222-238]. Харин онги ишний хэлбэрт хамаатуулж болох тамганууд бүлэг байдлаар холгүй орших Бөмбөгөрийн бичээст [Баттулга 2020, 100; Напил 2021:7-61], Хөтөл усны хүн чулуунд ч [Болдбаатар, Анхсанаа 2022: 92-98] тус тус дүрслэгдсэн нь анхаарал татна. Тиймээс тухайн бичээсийн агуулга, тамгуудын байрлал, хэмжээтэй холбогдуулан уг үйл хэргийн гол эзэд энэ орчимд нутагладаг хүмүүс бололтой гэж үзэхэд хүргэж байна.

Судалгааны дүгнэлт

Хар хороотын бичээс нь Монгол улсын нутгаас илрүүлсэн бага бичээсүүдийн дотор худалдааны харилцааг илэрхийлсэн анхны дурсгал болж байна. Тухайн үеийн хад чулуунд дүрслэгдсэн бичээст худалдаа арилжааны онцгой эрхтэй Согд нарын тухай [Мөнхтулга 2022: 74] тэмдэглэл үлджээ. Харин тамга дотор хамгийн том хэмжээтэй нь уг бичээсийн эзэн, энэ нутагт төвлөрөн суудаг Огузын Басмил, Карлукийн дунд суусан Тонра, Пугу аймгуудын төлөөлөл бололтой. Харин хэмжээгээр бага боловч янгир тамга нь Хожуу Түрэгийн үеийн хэрэг явдал байж болохыг дам зааж байна. Судлаачид Монгол нутгаас олдсон руни бичгийн байршилд дулдуйдаж тухайн үед хамаарах хэд хэдэн чиглэлд замын зураг гаргажээ. Хар хороотын руни бичгийн хувьд дээрх зургийн дагуу баруун тийш зорчих өврийн замын 2-р буудал [Баттулга 2022:51] буюу Байдрагийн голын орчмын дурсгалуудад хамаарна. Тиймээс бидний илрүүлсэн Хар хороотын дурсгал нь дээрх замын харилцааг илэрхийлэх нэгэн баримт мөн. Холбогдох цаг хугацаа, эзэн холбогдогчийн тухайд Хожуу Түрэгийн хаант улсын Билгэ хааны үед эсвэл Уйгурын хаант улсын үеийн өрнө дорныг холбож агсан Торгоны замын дагуух эдийн засаг, арилжаа худалдааны баримт болно.

Талархал

Хар хороотын руни бичгийн дурсгалын талаар мэдээ ирүүлж, замчилсан Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Баянбүрд багийн Засаг дарга П.Сайнбилэг, дурсгалыг өөрийн чадлаар хамгаалж өв соёлынхоо төлөө чин сэтгэл гаргаж яваа малчин С.Ганбат нартаа гүн талархал илэрхийлье.

Өгүүлэл хүлээн авсан: 2023 оны 01 сарын 17
Өгүүлэл засварласан: 2023 оны 02 сарын 15
Өгүүлэл хэвлэгдсэн: 2023 оны 6 сарын 30

Ном зүй

Анхбаяр, Буян-Орших 2022 – Анхбаяр Б., Буян-Орших Б. Баянхонгор аймгийн Бууцагаан, Өлзийт сумын нутагт ажилласан археологийн хээрийн шинжилгээний ангийн тайлан. //ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг.УБ., 2022.

Барс, Батболд 2022 – Барс М., Батболд Г. Янгир тамганы өөрчлөлт хийгээд нэмэлт тэмдэглэгээний тухайд.// Түрэг, Уйгур судлал: Turkic and Uighur Studies эрдэм шинжилгээний сэтгүүл. Tom III Fasc 7, УБ., 2022

Батболд 2017 – Батболд Г. Мартагдсан Пүгү аймаг. УБ., 2017.

Баттулга 2005 – Баттулга Ц. Бөмбөгөрийн бичээс.//Acta Mongolica. vol 4 (236). УБ., 2005.

Баттулга 2020 – Баттулга Ц. Бөмбөгөрийн бичээс. //Монголын археологийн өв цуврал зурагт цомог. Монголын руни бичгийн бага дурсгал XII боть. УБ., 2020

Баттулга 2005 – Баттулга Ц. Гурван мандалын бичээсийг дахин нягтлах нь. //Studa Archaeologica. Tom XII F-6. УБ.,2005

Баттулга 2022 – Баттулга Ц. Монголын руни бичгийн дурсгалын шинэ судалгаа. (Монголын баруун бүс нутаг дахь руни бичгийн судалгаа). Боть I. УБ.,2022

Баяр 2013 – Баяр Д. Гурван Мандалын хадны зураг. //Монголын дундад зууны археологийн судалгаа. Боть II. УБ., 2013

Болдбаатар, Анхсанаа 2022 – Болдбаатар Ю., Анхсанаа Г. Хөтөл уснаас олдсон тамгатай хүн чулуун хөшөө. //Түрэг, Уйгур судлал: Turkic and Uighur Studies эрдэм шинжилгээний сэтгүүл.Том III, Fasc 9. УБ., 2022.

Болд 1990 – БНМАУ-ын нутаг дахь хадны бичээсүүд 1990. УБ.

Мөнхтулга нар 2022 – Мөнхтулга Р., Амараа Д., Бүрэнтөгс Г. Таван толгойн руни бичээс.// Нүүдэлчдийн өв судлал. Tomus XXII., Fas 3. УБ. 2022

Мөнхтулга 2022 – Мөнхтулга Р. Монгол улсын нутаг дэвсгэр дахь эртний замын бичээсүүд. //"Гэрэлт хөшөө, хад чулуун дээр хадгалагдсан соёлын баримтат өвийн өнөөгийн байдал" Эрдэм шинжилгээ-онол практикийн хурлын эмхэтгэл. УБ., 2022

Напил 2021 – Напил Б. Их Талын нүүдэлчдийн тахилын онгон цогцолборууд болон хүн чулуун дурсгалууд: Түрэгийн үеийн угсаатан-соёлын онцлог. (Археологийн судалгааны сурвалжууд 1-р хэсэг) //Алтайстика, Тюркология, Монголистика международный научный журнал. Нүр-Сүлтан., г 2021.

Munkhtulga 2020 – Munkhtulga Rinchinkhorol. A Newly –Found Uighur period runic inscription // Ази судлал олон улсын эрдэм шинжилгээний зургаадугаар хурал.Volume VI.УБ., 2020

Talat Tekin 2010 – Talat Tekin. Orhon Yazitlary. Ankara., 2010

旧唐书 **1971** – 吴兢、韦述等《[旧唐书》卷195《回纥传》第5197页

Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/.



Зураг 1. Дурсгалт газрын байршил

Зураг 2. Хар хороотын хаваржаа, руни бичигтэй хадны байршил



Зураг 3. Руни бичиг, тамгат хад